

Банкуудын зээлийн тайлан


2016 оны 3 дугаар улирал

Нийт зээлийн үлдэгдэл өмнөх улирлаас 3.8 хувиар буюу 458.8 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 4.5 хувь буюу 535.4 тэрбум төгрөгөөр тус тус өсч 12.4 их наяд төгрөгт хүрчээ. Үүнээс татан буугдсан¹ банкуудын зээлийг хасч тооцвол нийт үлдэгдэл 12.2 их наяд төгрөг байна.


Харин банкуудаас Монголын Ипотекийн Корпорацид шилжүүлсэн² зээлийн багцыг оруулж тооцвол зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 7.1 хувиар өсч 14.4 их наяд төгрөг байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудаар авч үзвэл хэрэглээний, цалингийн болон тэтгэврийн зээл нийт зээлийн үлдэгдлийн 27.7 хувь, үл хөдлөх хөрөнгийн салбар³ 14.7 хувь, худалдааны салбар 13.2 хувь, барилгын салбар 11.1 хувь, боловсруулах үйлдвэрлэл 10.4 хувь, уул уурхайн салбар 7.8 хувь, бусад салбарууд 15.0 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 1. Зээлийн үлдэгдэл, түүний жилийн өөрчлөлт



Зураг 2. Зээлийн үлдэгдэл /гол салбараар/



¹ Зоос, Хадгаламж банк.

² МИК-д шилжүүлсэн 2.17 их наяд төгрөгийн зээлийн дүн нь банкны салбарын үзүүлэлтээс хасагдаж, бусад санхүүгийн байгууллагын үзүүлэлтэд тусгагддаг.


³ МИК-д шилжүүлсэн орон сууцны ипотекийн зээлийг хассанаар

Нийт зээлийн үлдэгдлийн 79.1 хувь нь төгрөгийн, 20.9 хувь нь валютаар олгогдсон зээл байгаа бөгөөд хөдөө аж ахуйн зээл, орон сууцны ипотекийн зээл, хэрэглээний зээл төгрөгөөр түлхүү олгогдож байгаа бол санхүү даатгал, мэдээлэл холбоо, боловсрол болон цахилгаан, хий, агааржуулалтын хангамжийн салбарт валютын зээл давамгайлж байна.


Зээлийн жилийн өсөлт 2014 оны эхнээс саарч, 2015 оны 2 дугаар улирлаас сөрөг үзүүлэлттэй байсан бол тайлант улиралд өнгөрсөн оны мөн үеэс 9.9 нэгж хувиар өсч, жилийн өсөлт нь 4.5 хувьд (МИК-д шилжүүлсэн багцыг хассанаар) хүрч эерэг үзүүлэлттэй гарлаа. Үл хөдлөх хөрөнгийн салбар болон хэрэглээний зээл өссөн, боловсруулах үйлдвэрлэлийн болон худалдааны салбарын зээл олголт харьцангуй тогтвортой байгаа зэрэг нь нийт зээлийн өсөлт эерэг үзүүлэлттэй гарахад нөлөөлсөн байна. Харин уул уурхай болон барилгын салбарын зээлийн үлдэгдэл өнгөрсөн оны мөн үеэс дунджаар 13.0 хувиар буурсан байна.

Тайлант улиралд банкууд нийт 2 их наяд 828.3 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. Шинээр олгосон зээл өмнөх улирлаас 12.7 хувь буюу 411.5 тэрбум төгрөгөөр буурсан бол өнгөрсөн оны мөн үеэс 10.5 хувь буюу 268.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.


Зураг 3. Зээлийн үлдэгдэл /төгрөг, валютаар/



Зураг 4. Зээлийн жилийн өсөлтийн задаргаа /гол салбараар/



Зураг 5. Олгосон, төлөгдсөн зээл




Гол салбарууд дахь чанаргүй зээлийн хувийг /Зоос, Хадгаламж банкуудыг хассанаар/ авч үзвэл уул уурхайн олборлолтын салбарт 29.3 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 11.1 хувь, бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт 9.1 хувь, хөдөө аж ахуйн салбарт 7.6 хувь, барилгын салбарт 6.1 хувь байна. Харин хугацаа хэтэрсэн зээлийн хувьд уул уурхайн салбарт 32.1 хувь, барилгын салбарт 7.9 хувь, хөдөө аж ахуйн салбарт 7.8 хувьтай байна.

Нийт банкны салбарын чанаргүй зээлийн 27.7 хувийг уул уурхайн салбар, 15.6 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбар, 15.4 хувийг худалдааны салбар, 9.1 хувийг барилгын салбар, 10.7 хувийг бусад салбаруудын чанаргүй зээл бүрдүүлж байна.

Банкууд чанаргүй зээлээс үүдэж гарах алдагдлаас хэр хамгаалагдсан байгаа эсэхийг тодорхойлдог эрсдэлийн сангийн хүрэлцээний харьцаа (provision coverage ratio)-г салбар бүрээр авч үзвэл усан хангамж, цахилгаан, боловсрол, худалдаа зэрэг гол салбаруудын харьцаа хүрэлцээтэй түвшинд байгаа бол хөдөө аж ахуй, мэдээлэл холбоо, байр, сууцны үйлчилгээний салбар дахь уг харьцаа бага байна.

Хувийн хэвшил, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл банкны салбарын зээлийн 99.1 хувийг бүрдүүлжээ. Хувийн хэвшлийн зээлийн үлдэгдлийн 19.1 хувийг барилгын салбарт, 18.7 хувийг худалдааны салбарт, 17.6 хувийг боловсруулах үйлдвэрийн салбарт, 13.9 хувийг уул уурхайн салбарт, 30.6 хувийг бусад салбарт тус тус олгожээ.


Зураг 9. Чанаргүй зээл, хугацаа хэтэрсэн зээл /тухайн салбартаа эзлэх хувиар/



Зураг 10. Эрсдэлийн сан, чанаргүй зээлийн харьцаа



Зураг 11. Хувийн байгууллагын зээл



Иргэдийн зээлийн үлдэгдлийн 51.0 хувийг орон сууцны ипотекийн зээл (МИК-д шилжүүлсэн зээлийг оруулснаар) бүрдүүлж байгаа бол 39.3 хувийг цалингийн зээл, хадгаламж барьцаалсан зээл, картын зээл, тэтгэврийн зээл болон бусад хэрэгцээнд зориулсан зээл, 4.7 хувийг бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 5.0 хувийг бусад салбарт тус тус олгосон байна.


Хувийн байгууллагын зээлийн жилийн өсөлт 6.4 хувьтай байгаа бол иргэдийн зээл 4.3 хувиар өссөн үзүүлэлтэй байна. Өмнөх улирлын зээлийн үлдэгдэлтэй харьцуулахад иргэдийн зээл 7.8 нэгж хувиар, хувийн хэвшлийн зээл 2.5 нэгж хувиар нэмэгдсэн байна. Харин МИК-д шилжүүлсэн зээлийн багцыг оруулж тооцвол иргэдийн зээл өмнөх оноос 9.3 хувиар өссөн байна.

Тухайн салбарт олгосон зээлийн үлдэгдлийг зээлдэгчдийн тоонд нь харьцуулахад уул уурхайн салбар хамгийн өндөр (4 тэрбум 351 сая ₮) дүнтэй байгаа бол мэдээлэл холбоо (655.3 сая ₮), санхүүгийн үйлчилгээ (504.2 сая ₮), барилгын салбар (489.1 сая ₮) удаалж байна. Харин нийт зээлд өндөр хувь эзэлдэг худалдаа, орон сууцны ипотекийн зээлийн нэгж зээлийн хэмжээ тус бүр 69.2, 49.2 сая төгрөгийн хооронд байгаа бол хэрэглээний зээлийн хувьд хамгийн бага дүнтэй буюу 4.3 сая төгрөг байна.

Зураг 12. Иргэдийн зээл, бүтцээр



Зураг 13. Иргэд, хувийн хэвшилд олгосон зээлийн жилийн өсөлт



Зураг 14. Нэгж зээлийн хэмжээ⁴




⁴ Уул уурхайн салбарыг тус дүрслэлд харуулаагүй

Тайлант улиралд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүүг салбараар авч үзвэл, барилгын салбар (21.0%), хөдөө аж ахуйн салбар (20.8%) болон хэрэглээний зээл (20.0%) нь өндөр хувьтай байгаа бол худалдаа (15.8%), боловсруулах (15.5%) салбарт олгосон зээлийн хүү харьцангуй бага байна.

Банкуудын тайлант улиралд олгосон зээлийн жигнэсэн дундаж хугацаа⁵ 1.9 жил байна.

Зураг 15. Олгосон зээлийн хүү /салбараар/



⁵ Тайлант улиралд олгосон ОСИЗ-ийн жигнэсэн дундаж хугацааг хассанаар

Иргэд, жижиг дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгжид олгосон зээл


Тайлант улиралд иргэдийн зээл 5 их наяд 490.5 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаагийн 31.6 хувь буюу 1 их наяд 732.5 тэрбум төгрөг нь ипотекийн, 26.9 хувь буюу 1 их наяд 479.5 тэрбум төгрөг нь цалингийн, 13.2 хувь буюу 723.0 тэрбум төгрөг нь жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх, 9.7 хувь буюу 532.9 тэрбум төгрөг нь тэтгэврийн, 5.6 хувь буюу 309.3 тэрбум төгрөг нь хэрэглээний, 12.9 хувь буюу 713.2 тэрбум төгрөг нь бусад зээл байна.

Иргэдийн нийт зээлд эзлэх чанаргүй зээл 3.4 хувь байгаагаас хэрэглээний зээл 3.3 хувь, цалингийн зээл 2.4 хувь, ипотекийн зээл 1.9 хувьтай байна. Тэтгэврийн зээлийн эргэн төлөлт харьцангуй сайн байна.


Иргэдэд олгосон зээлийн дундаж хүү жилийн 18.5 хувь байгаа бөгөөд хэрэглээний (20.4%) болон цалингийн (20.7%) зээлийн хүү харьцангуй өндөр байна. Харин иргэдийн зээлийн дундаж хугацааны хувьд орон сууцны ипотекийн зээл 232.4 сар (19.4 жил), цалингийн зээл 43.7 сар (3.6 жил) байгаа бол тэтгэврийн зээлийн хувьд 7.1 сар байна.

Тайлант улиралд жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ) эрхлэх зориулалтаар аж ахуйн нэгж болон иргэдэд нийт 335.2 тэрбум төгрөгийн зээл олгож, тайлант улирлын эцэст нийт 42650 иргэд, 4896 аж ахуйн нэгжүүд 2061.8 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

Зураг 16. Иргэдийн зээл /зориулалтаар/




Зураг 17. Чанаргүй зээлийн хувь /зориулалтаар/



	Зээлийн дундаж хүү /хувь/	Зээлийн дундаж хугацаа /сар/
Иргэдийн зээл	18.5%	55.5
Ипотекийн зээл	8.2%	232.4 (19.4 жил)
Хэрэглээний зээл	20.4%	15.2
Цалингийн зээл	20.7%	43.7 (3.6 жил)
Тэтгэврийн	18.0%	7.1
Бусад зээл	20.6%	12.0

Зураг 18. ЖДҮ-ийн зээлийн хэмжээ /салбараар/




Үүнээс 35.1 хувь буюу 723.1 тэрбум төгрөг нь ЖДҮ эрхлэгч иргэдийн зээл, 64.9 хувь буюу 1 их наяд 338.7 тэрбум төгрөг нь ЖДҮ эрхлэгч аж ахуйн нэгжийн зээл байна. ЖДҮ-ийн зээлийг салбараар авч үзвэл худалдаа (32.6%) болон боловсруулах үйлдвэрлэлийн салбар (22.1%)-т түлхүү олгогдсон байна.

ЖДҮ-ийн нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь 12.1 хувь байгаа бөгөөд үйлчилгээ, барилга, хөдөө аж ахуйн салбарын ЖДҮ эрхлэгч иргэдэд олгосон зээлийн чанаргүй зээлийн хувь харьцангуй өндөр байгаа бол аж ахуйн нэгжүүдийн чанаргүй зээлийн хувь харьцангуй бага байна.

ЖДҮ эрхлэгчдэд олгож буй зээлийн дундаж хүү болон хугацааг харьцуулахад иргэдэд олгогдож буй зээлийн хүү (22.7%) харьцангуй өндөр, урт хугацаа (26.7 сар)-тай байгаа бол ААН-ийн зээлийн хүү бага (18.2%), харин дундаж хугацаа нь харьцангуй богино (24.6 сар) байна.

Зураг 19. ЖДҮ-ийн чанаргүй зээлийн хувь



Зураг 20. ЖДҮ-ийн зээлийн хүү, хугацаа

